



I-III/2022

Тархаасан: 2022 оны 4 дүгээр сарын 13




Улсын хилээр орсон гадаадын зорчигчид өмнөх оны мөн үеэс 10.5 мянга буюу 3.6 дахин өссөн байна

Манай улсын хилээр 2022 оны 1 дүгээр улиралд 150.7 (давхардсан тоогоор) мянган зорчигч нэвтэрсэн нь өмнөх оны мөн үеэс 39.2 (20.7%) мянгаар буурчээ.

Мөн оны 1 дүгээр улиралд 74.9 мянган зорчигчид хилээр орсон байна. Улсын хилээр орсон зорчигчдын 16.0 хувь нь Гашуун сухайт, 10.3 хувь нь Замын-Үүд, 9.5 хувь нь Алтанбулаг, 9.3 хувь нь Булган, 6.0 хувь нь Ханги, 49.0 хувь нь бусад боомтоор орсон байна.

Улсын хилээр орсон зорчигчдын 60.3 (80.6%) мянга нь Монгол Улсын иргэд, 14.5 (19.4%) мянга нь гадаад улсын иргэд байна.

ЗУРАГ 1. МОНГОЛ УЛСЫН ХИЛЭЭР ОРСОН ЗОРЧИГЧИД, боомтоор, дүнд эзлэх хувиар, жил бүрийн 1 дүгээр улирлын байдлаар



Улсын хилээр 2022 оны 1 дүгээр улирлын байдлаар гадаадын 14.5 мянган хүн орсон нь өмнөх оны мөн үеэс 10.5 мянгаар буюу 3.6 дахин нэмэгдсэн бол өмнөх оны жилийн эцэстэй харьцуулахад 24.7 (63.0%) мянгаар буурчээ. Тэдний 80.5 хувь нь 30 хүртэл хоног, 3.5 хувь нь 30-аас 90 хүртэл хоног, 16.0 хувь нь 90, түүнээс дээш хоногийн хугацаагаар ирсэн байна.

ХҮСНЭГТ 1. МОНГОЛ УЛСЫН ХИЛЭЭР ОРСОН ГАДААД ЗОРЧИГЧИД, бүс нутаг, улсаар, жил бүрийн 1 дүгээр улирлын байдлаар

| Бүс нутаг, улсаар | 2019 I-III | 2020 I-III | 2021 I-III | 2022 I-III |
|--|---------------|---------------|--------------|---------------|
| Зүүн Ази, Номхон далайн бүс нутаг | 52 594 | 17 763 | 1 518 | 4 817 |
| БНХАУ | 34 980 | 8 139 | 1 114 | 1 788 |
| БНСУ | 8 084 | 5 233 | 140 | 1 679 |
| Казахстан | 2 101 | 1 349 | 80 | 340 |
| Европ | 31 401 | 20 851 | 2 215 | 7 476 |
| ОХУ | 26 582 | 18 135 | 1502 | 5 170 |
| Беларусь | 571 | 572 | 594 | 1 175 |
| Герман | 888 | 460 | 29 | 245 |
| Америк | 3 169 | 1 475 | 1 78 | 907 |
| АНУ | 2 214 | 1 083 | 146 | 736 |
| Канад | 702 | 276 | 29 | 129 |
| Бразил | 70 | 33 | 2 | 6 |
| Өмнөд Ази | 561 | 254 | 71 | 321 |
| БНЭУ | 409 | 195 | 71 | 243 |
| Иран | 59 | 19 | - | 43 |
| Балба | 35 | 13 | - | 11 |
| Ойрх Дорнод | 374 | 534 | 39 | 798 |
| Турк | 246 | 492 | 37 | 773 |
| Израйл | 32 | 20 | - | 19 |
| Катар | 55 | 11 | - | - |
| Африк | 481 | 284 | 3 | 199 |
| Өмнөд Африк | 400 | 243 | 1 | 158 |
| Гана | 6 | 9 | - | 3 |
| Кени | 6 | 8 | - | 1 |
| Харьяалалгүй | 5 | 2 | - | - |
| Нийт | 88 585 | 41 163 | 4 024 | 14 518 |

Энэ оны 1 дүгээр улиралд улсын хилээр орсон гадаадын зорчигчдын 13.9 (95.7%) мянга нь насанд хүрсэн хүн, 626 (4.3%) нь хүүхэд, 2.8 (19.0%) мянга нь эрэгтэйчүүд, 11.8 (81.0%) мянга нь эмэгтэйчүүд байна.

Улсын хилээр орсон гадаадын зорчигчдын 51.5 хувь нь Европ, 33.2 хувь нь Зүүн Ази, Номхон Далайн бүс нутаг, 6.2 хувь нь Америк, 9.1 хувь нь Ойрх Дорнод, Өмнөд Ази, Африк тивээс иржээ. Хилээр орсон гадаадын зорчигчдын 12.3 хувийг БНХАУ-ын иргэд, 35.6 хувийг ОХУ-ын иргэд, 5.1 хувийг АНУ-ын иргэд, 11.6 хувийг БНСУ-ын иргэд, 8.1 хувийг Беларусь, 2.3 хувийг Казахстан улсын иргэд, 25.0 хувийг бусад улсын иргэд тус тус эзэлж байна.

Манай улсын 63.4 (давхардсан тоогоор) мянган иргэн 2022 оны 1 дүгээр улиралд гадаадад зорчсоноос 39.5 (62.4%) мянга нь аялал жуулчлалын зорилгоор зорчсон нь өмнөх оны мөн үеэс 25.6 (39.3%) мянгаар буурсан бол 23.8 (37.6%) мянга нь ажиллах, суралцах болон байнга оршин суух зорилгоор зорчсон нь өмнөх оны мөн үеэс 901 (3.6%) -ээр тус тус буурсан байна.

Хилээр нэвтэрсэн жуулчдын тоо энэ оны 1 дүгээр улиралд 12.2 мянга болсон нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 8.5 мянгаар буюу 3.3 дахин өссөн ба өмнөх оны жилийн эцэстэй харьцуулахад 20.9 мянган (37.0%) жуулчдаар бага байна.

Улсаар ангилж үзвэл энэ оны 1 дүгээр улиралд БНХАУ-ын жуулчид 426 (38.3%)-аар, ОХУ-ынх 3075 жуулчдаар буюу 3.1 дахин, Өмнөд Солонгос Улсынх 1341 жуулчдаар буюу 15.0 дахин, Америкийн Нэгдсэн Улсынх 471 жуулчдаар буюу 4.3 дахин тус тус нэмэгджээ.

ХҮСНЭГТ 2. ГАДААДАД ЗОРЧСОН МОНГОЛ УЛСЫН ИРГЭД, жил бүрийн 1 дүгээр улирлын байдлаар, сонгогдсон улсаар

| Зорчсон улсын нэр | 2019 I-III | 2020 I-III | 2021 I-III | 2022 I-III |
|-------------------|----------------|----------------|---------------|---------------|
| Бүгд | 548 802 | 221 580 | 89 887 | 63 379 |
| Австрали | 1 490 | 763 | 18 | 596 |
| АНУ | 3 350 | 2 045 | 354 | 1 840 |
| АНЭУ | 572 | 254 | 14 | 968 |
| БНСУ | 23 720 | 15 766 | 1 114 | 4 295 |
| БНХАУ | 408 383 | 131 165 | 85 298 | 30 362 |
| ОХУ | 75 731 | 44 488 | 1 523 | 6 365 |
| Тайланд | 4 517 | 1 962 | 5 | 3 443 |
| Турк | 1 543 | 2 834 | 140 | 7 527 |
| ХБНГУ | 2 175 | 1 578 | 210 | 922 |
| Япон | 7 344 | 3 971 | 173 | 1 917 |
| Бусад | 19 977 | 16 754 | 1 038 | 6 984 |

Гадаадад зорчсон Монгол Улсын иргэдийн 15.3 (25.1%) мянга нь эрэгтэйчүүд, 47.5 (74.9%) мянга нь эмэгтэйчүүд, 3291 (5.2%) нь хүүхэд байна.

Тэдний 55.4 (87.4%) мянга нь 30 хүртэл хоног, 961 (1.5%) нь 30-аас 90 хүртэл хоног, 7.0 (11.0%) мянга нь 90, түүнээс дээш хоногийн хугацаагаар явсан байна.


Улсын хилээр 2022 оны 1 дүгээр улиралд 253.8 (давхардсан тоогоор) мянган тээврийн хэрэгслийг нэвтрүүлсэн нь өмнөх оны мөн үеэс 148.5 (36.9%) мянгаар өсжээ.

Тэдгээрийн 25.9 хувийг ачааны машин, 0.4 хувийг суудлын машин, 71.6 хувийг ачааны вагон, 2.2 хувийг бусад тээврийн хэрэгсэл эзэлж байна.


Нийт тээврийн хэрэгслийн 58.2 хувь нь Замын-Үүд, 9.5 хувь нь Гашуун сухайт, 18.0 хувь нь Тавт, 3.4 хувь нь Алтанбулаг, 10.9 хувь нь бусад боомтоор тус тус нэвтэрсэн байна.

ЗУРАГ 2. МОНГОЛ УЛСЫН ХИЛЭЭР НЭВТРҮҮЛСЭН ТЭЭВРИЙН ХЭРЭГСЭЛ, жилийн бүрийн 1 дүгээр улирлын байдлаар, дүнд эзлэх хувиар, боомтын төрлөөр

2021 I-III



2022- I-III



Аргачлалын тайлбар:

Монгол Улсын хилээр нэвтэрсэн зорчигчдод гадаадын болон дотоодын иргэдийг хамруулав. Монгол Улсын хилээр орсон зорчигчдыг зорилгоор нь албаны, хувийн, жуулчлал, дамжин өнгөрөх, суралцах, ажиллах, байнга оршин суух, бусад гэж ангилна.

Жуулчин: Байнга оршин суудаг газраасаа өөр газарт албаны, хувийн, жуулчлал, дамжин өнгөрөх, бусад зорилгоор 183 хоногоос доош хугацаагаар аялж буй гадаадын иргэн юм.



Эх үүсвэр:

Хил хамгаалах ерөнхий газар

Мэдээлэл авах холбоос:

<http://www.nso.mn/>
<http://www.1212.mn/>

Дараагийн мэдээ тархаах хуваарь:

2022 оны 7 дугаар сарын 19

Тооллого, өгөгдөл, шинжилгээ судалгааны газрын дарга Ш.Ариунболд
Утас : (976-51)-261523

Тооллого, өгөгдөл, шинжилгээ судалгааны Хүн ам, орон сууцны тооллогын хэлтсийн статистикч Б.Гэрэл
Утас : (976-51)-267547



/StatisticMGL



information@nso.mn



1900-1212